

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/77/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас:99417382 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

НОГООННУУР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ К.АУКЕТАЙ
ТАНАА

2023.02.24 № 167
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилт нь 2022 оны нийт орлогын 97.4 хувийг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>112,939,188.96</u>	<u>331,026,267.87</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	169,219,561.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	-	169,219,561.00
Төгрөг	-	169,219,561.00
Төрийн сангийн харилцах		169,219,561.00
АВЛАГА	44,710,512.21	-
Ажиллагчидтай холбогдсон авлага	3,040,512.21	
Төлбөртэй үйлчилгээний авлага	41,670,000.00	
БАРАА МАТЕРИАЛ	68,228,676.75	161,806,706.87
Түүхий эд материал	20,448,036.61	103,978,532.87
Тусгай зориулалттай материал		
Эм боох материал	20,448,036.61	103,978,532.87
Дуусаагүй үйлдвэрлэл		
Бэлэн бүтээгдэхүүн		
Хангамжийн материал	37,440,640.14	46,128,174.00
Бичиг хэргийн материал	1,323,780.00	1,674,310.00
Аж ахуйн материал		
Сэлбэг хэрэгсэл		
Түлш, шатах тослох материал	777,493.00	3,865,653.00
Барилгын засварын материал		
Хүнсний материал	3,671,513.30	6,676,745.00
Бусад хангамжийн материал	31,667,853.84	33,911,466.00
Биологийн хөрөнгө		
Мал амьтад	10,340,000.00	11,700,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,225,323,998.88</u>	<u>1,224,230,111.11</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,225,323,998.88	1,224,230,111.11
Газар		
Биет хөрөнгө	1,196,279,598.88	1,195,185,711.11
Барилга, байгууламж, орон сууц	1,120,131,212.00	1,130,131,212.00
Хуримтлагдсан элэгдэл	(95,226,020.28)	(126,746,727.84)
Авто-тээврийн хэрэгсэл	147,246,429.00	147,246,429.00
Хуримтлагдсан элэгдэл	(76,031,576.51)	(101,000,148.67)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	264,264,543.65	348,582,360.45
Хуримтлагдсан элэгдэл	(202,466,074.26)	(237,297,396.05)
Тавилга, аж ахуйн эд хогшил	71,408,810.00	74,698,810.00
Хуримтлагдсан элэгдэл	(33,474,124.70)	(40,788,327.78)
Зам, гүүрийн байгууламж	233,000.00	233,000.00
Бусад үндсэн хөрөнгө	866,732.00	866,732.00
Хуримтлагдсан элэгдэл	(799,832.02)	(866,732.00)
Дуусаагүй барилга, байгууламж		
Ном	126,500.00	126,500.00
Биет бус хөрөнгө	29,044,400.00	29,044,400.00
Програм хангамж	550,000.00	550,000.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
Бусад биет бус хөрөнгө	29,044,400.00	29,044,400.00
Хуримтлагдсан элэгдэл		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,338,263,187.84</u>	<u>1,555,256,378.98</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,338,263,187.84</u>	<u>1,555,256,378.98</u>
Засгийн газрын хувь оролцоо	1,338,263,187.84	1,555,256,378.98
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	699,896,598.00	699,896,598.00
Өмч: - төрийн	699,896,598.00	699,896,598.00
Хуримтлагдсан үр дүн	(96,536,431.64)	120,456,759.50
Өмнөх үеийн үр дүн	(96,536,431.64)	(96,536,431.64)
Тайлант үеийн үр дүн		216,993,191.14
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	734,903,021.48	734,903,021.48
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,338,263,187.84</u>	<u>1,555,256,378.98</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,148,812,839.49	1,132,881,962.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,348,498.84	135,608,172.29
120	Нийтлэг татварын бус орлого	50,348,498.84	135,608,172.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,348,498.84	135,608,172.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		320,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,348,498.84	135,288,172.29
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,098,464,340.65	997,273,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	874,609,694.65	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	805,553,900.00	
131005	Хөрөнгийн санхүүжилт	69,055,794.65	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,334,646.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,334,646.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,903,500.00	26,340,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		26,340,700.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	1,903,500.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	163,616,500.00	970,933,090.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	163,616,500.00	970,933,090.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,088,724,415.97	915,888,771.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,088,724,415.97	915,888,771.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,324,415.97	915,888,771.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,692,074.07	565,706,728.93
210101	Үндсэн цалин	413,588,928.79	355,670,644.00
210102	Нэмэгдэл	116,487,644.15	105,722,084.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,984,090.00	9,369,000.00
210104	Урамшуулал	53,779,800.00	47,784,975.00
210105	Гэрээт ажлын хөлс	55,851,611.13	47,160,025.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,361,246.72	72,212,875.28
210201	Тэтгэврийн даатгал	75,361,246.72	72,212,875.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,407,262.00	18,999,954.00
210301	Гэрэл, цахилгаан	2,250,921.00	2,463,624.00
210302	Түлш, халаалт	17,156,341.00	16,536,330.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	65,396,392.00	67,739,611.84
210401	Бичиг хэрэг	2,446,065.00	2,311,670.00
210402	Тээвэр, шатахуун	48,134,550.00	52,982,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	42,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,615,777.00	5,993,360.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		6,410,581.84
2105	Нормативт зардал	128,315,970.15	82,465,986.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,191,703.45	59,922,718.23
210502	Хоол, хүнс	28,085,866.70	22,543,268.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	38,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,074,000.00	4,404,620.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000.00	87,000.00
210604	Урсгал засвар	1,058,000.00	4,317,620.00
2107	Томилолт, зочны зардал	1,736,639.00	1,128,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,736,639.00	1,128,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,696,180.00	3,476,890.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	87,450.00	213,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		82,440.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,882,000.00	1,961,000.00
210807	Газрын төлбөр	280,000.00	280,000.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26,730.00	274,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,644,652.03	99,754,104.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	745,600.00	1,052,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,899,052.03	98,701,704.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,400,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	57,400,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>60,088,423.52</u>	<u>216,993,191.14</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,947,673.80	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,947,673.80	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,947,673.80)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>53,140,749.72</u>	<u>216,993,191.14</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>985,835,046.00</u>	<u>1,039,263,790.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	320,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	320,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	320,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		320,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	985,835,046.00	1,038,943,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	805,553,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	805,553,900.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,334,646.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,334,646.00	
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	26,340,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		26,340,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	121,946,500.00	1,012,603,090.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	121,946,500.00	1,012,603,090.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>975,780,046.00</u>	<u>818,041,229.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	975,780,046.00	818,041,229.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	918,380,046.00	818,041,229.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	646,041,740.00	562,699,133.00
210101	Үндсэн цалин	410,593,568.18	341,461,463.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	116,487,644.15	120,000,225.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,984,090.00	8,285,000.00
210104	Урамшуулал	53,779,800.00	44,818,951.00
210105	Гэрээт ажлын хөлс	57,196,637.67	48,133,494.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,161,100.00	72,175,100.00
210201	Тэтгэврийн даатгал	57,113,400.00	46,780,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,011,900.00	6,957,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,809,500.00	4,750,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,202,400.00	1,285,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,023,900.00	12,400,600.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,944,100.00	22,734,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,734,400.00	4,734,400.00
210302	Түлш, халаалт	16,209,700.00	18,000,000.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	54,569,100.00	58,069,550.00
210401	Бичиг хэрэг	1,934,000.00	2,507,200.00
210402	Тээвэр, шатахуун	42,300,100.00	48,512,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	42,000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,135,000.00	283,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,000,000.00	6,724,450.00
2105	Нормативт зардал	107,849,660.00	84,661,539.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,526,160.00	65,155,159.00
210502	Хоол, хүнс	21,500,500.00	17,732,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,823,000.00	1,774,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,562,360.00	11,173,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	956,060.00	2,409,800.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,606,300.00	8,764,190.00
2107	Томилолт, зочны зардал	1,736,646.00	1,128,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,736,646.00	1,128,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,524,900.00	3,911,413.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	87,500.00	213,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,400.00	82,440.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,972,000.00	2,055,523.00
210807	Газрын төлбөр	280,000.00	280,000.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	614,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	990,440.00	1,488,104.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	990,440.00	1,488,104.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,400,000.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	57,400,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,055,000.00	221,222,561.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,055,000.00	52,003,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,055,000.00	52,003,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,055,000.00	52,003,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,055,000.00	52,003,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,055,000.00)	(52,003,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	169,219,561.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	(96,536,431.64)		1,338,263,187.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	(96,536,431.64)	-	1,338,263,187.84
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн				-	-
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	(96,536,431.64)	-	1,338,263,187.84
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	(96,536,431.64)	-	1,338,263,187.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	(96,536,431.64)	-	1,338,263,187.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			216,993,191.14		216,993,191.14
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	120,456,759.50	-	1,555,256,378.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,138,422,300.00	870,044,229.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,138,422,300.00	870,044,229.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,138,422,300.00	870,044,229.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,784,700.00	562,699,133.00
210101	Үндсэн цалин	416,566,900.00	341,461,463.00
210102	Нэмэгдэл	134,774,300.00	120,000,225.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,332,000.00	8,285,000.00
210104	Урамшуулал	58,130,100.00	44,818,951.00
210105	Гэрээт ажлын хөлс	48,981,400.00	48,133,494.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,416,300.00	72,175,100.00
210201	Тэтгэврийн даатгал	58,763,100.00	47,788,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,913,300.00	5,950,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,530,600.00	4,750,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,382,700.00	1,285,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,826,600.00	12,400,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,734,400.00	22,734,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,734,400.00	4,734,400.00
210302	Түлш, халаалт	18,000,000.00	18,000,000.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	85,028,900.00	58,069,550.00
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	2,507,200.00
210402	Тээвэр, шатахуун	66,778,900.00	48,512,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	42,000.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	283,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,250,000.00	6,724,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	129,080,000.00	84,661,539.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,992,200.00	65,155,159.00
210502	Хоол, хүнс	27,587,800.00	17,732,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,500,000.00	1,774,150.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	130,077,700.00	61,046,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	118,871,400.00	52,282,800.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	11,206,300.00	8,764,190.00
2107	Томилолт, зочны зардал	2,580,000.00	1,128,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,580,000.00	1,128,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,861,000.00	3,911,413.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	213,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,000.00	82,440.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200,000.00	2,055,523.00
210807	Газрын төлбөр	280,000.00	280,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	614,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,859,300.00	3,618,104.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,859,300.00	3,618,104.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,138,422,300.00	1,039,263,790.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,340,700.00	26,340,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	26,340,700.00	26,340,700.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,111,761,600.00	1,012,603,090.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,111,761,600.00	1,012,603,090.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	320,000.00	320,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	320,000.00	320,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		169,219,561.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	51.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	36.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
620004	Гэрээт ажилтан		7.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45	51

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	38	37
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7
650010	Гэрээт ажилтан		7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байгууллага.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд “Үр дүнтэй манлайлал бүхий хамт олныг бүрдүүлэн байгууллагын хөгжлийг хангаж, харьяа нутгийн хүн амын эрүүл мэндэд ээлтэй, чанартай, цогц тусламж үйлчилгээг үзүүлэх замаар орон нутгийн хөгжил, амьдралын чанарыг сайжруулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй, нээлттэй байх
- Эрүүл энх, эрх тэгш байх
- Чанартай, хүртээмжтэй, цогц байх
- Ёс зүйтэй, мэдрэмжтэй байх
- Өндөр мэргэшсэн, сайн чадавхтай байх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- ❖ Эрүүл мэндийн тухай хууль
- ❖ Бага дунд боловсролын тухай хууль
- ❖ Төрийн албаны тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Шилэн дансны тухай хууль
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ❖ Татварын тухай хууль гэх мэт

Тайланд хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Тайлант оноос үйл ажиллагааны хувьсах зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоонд шилжиж, санхүүгийн тайлангаа Эрүүл мэндийн яаманд нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Эрүүл мэндийн яамны салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах тухай” 138 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдсөн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нягтлан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 217.0 сая төгрөгөөр буюу 16.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		169,219.6	169,219.6
Авлага	44,710.5		(44,710.5)
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	68,228.7	161,806.7	93,578.0
Үндсэн хөрөнгө	1,225,324.0	1,224,230.1	(1,093.9)
Нийт хөрөнгө	1,338,263.2	1,555,256.4	216,993.2
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,338,263.2	1,555,256.4	216,993.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,338,263.2	1,555,256.4	216,993.2

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос мөнгөн хөрөнгө, бараа материал, Засгийн газрын хувь оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Оны эцэст улсын төсвийн санхүүжилтээс 169.2 сая төгрөгийн төсөв хэмнэгдэж мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнаж, оны эхний 44.7 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг бүрэн барагдуулсан.

Оны эхэнд бараа материалын данс 68.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 178.5 сая төгрөгийн, үнэгүй 89.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч 168.2 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан. Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/10 дугаар тушаалаар 6.4 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 1633.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр 52.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 45.6 сая төгрөгийн дансны үнэтэй хөрөнгийг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Үндсэн хөрөнгөд 98.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1555.2 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 217.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүждэг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1138.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1112.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 26.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1013.0 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 26.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.2 сая төгрөг буюу 91.3 хувьтай байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 99.2 сая төгрөгийн санхүүжилтийг сангаас дутуу авсантай холбоотой. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжилтээ дутуу авсан ч жилийн эцэст өргүй гарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	80302-Нэг иргэнд ногдох нормативаар	478,260.9	433,183.9	45,077.0	90.6	
2	81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	582,190.0	528,999.2	53,190.8	90.9	
3	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	51,630.9	50,740.0	890.9	98.3	
4	80112-Нийтлэг үйлчилгээ	26,340.7	26,340.7	-	100.0	
	Дүн	1,138,422.5	1,039,263.8	99,158.7	91.3	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тайлант онд нэмэлт дансаар санхүүжилт аваагүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1088.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 16.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийн дансанд 169.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад Эрүүл мэндийн төвийн дарга 30 хувийн буюу 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал авч, ахлах сувилагчаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан хавсралтад заасан нэр бүхий иргэнд тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгосон боловч цалингийн зардлаас 0.8 сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг давхар олгосон байна. Мөн нийтдээ 52.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад хуулийн дагуу мэдээллээ хугацаанд нь бүрэн оруулсан байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилтийн 100 хувь байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 399.7 сая төгрөгийн зөрчил илэрч 13.4 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 386.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах зөвлөмж хүргүүлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 339.7 сая төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож, оны эцэст үүссэн 42.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулаагүй, тайлант онд төсвөөс шуудан холбоо, гэрэл цахилгааны зардалд зарцуулсан нийт 4.3 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	386,300.0	2	386,300.0	100%
Нийт дүн	2	386,300.0	2	386,300.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.8 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр дараах зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Эрүүл мэндийн төвийн дарга нь 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн сумын Засаг даргын 146 дугаар захирамжаар даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдож, II дугаар улирлын ажилчдын үр дүнгийн урамшуулал олгох 7 дугаар сарын 25-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар өөртөө 30 хувийн буюу 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсныг нөхөн төлүүлэх акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1.Төвийн ахлах сувилагчаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан хавсралтад заасан нэр бүхий иргэнд тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгосон боловч цалингийн зардлаас 0.8 сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг давхар олгосон зөрчилд албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

1.1. Илрүүлэлт:

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд “Авилмансур” ХХК-аас 0.5 сая төгрөгийн, “Бек импекс” ХХК-аас 4.4 сая төгрөгийн, “Өлгий цахим” ХХК-аас 6.0 сая төгрөгийн, “Дипирамид” ХХК-аас 15.5 сая төгрөгийн, “Ач есөн энх” ХХК-аас 17.2 сая төгрөгийн, “Фарфат” ХХК-аас 5.8 сая төгрөгийн, “Мед буян” ХХК-аас 0.6 сая төгрөгийн, иргэн Ч.Оюунаас 2.0 сая төгрөгийн, нийтдээ 52.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг шууд гэрээгээр худалдан авч төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/		Зөвлөмж
				Үүнээс		
				Залруулсан	Залруулаагүй	

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Тоо	Дүн										
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлттэй холбоотой зөрчил								
Үр дүнгийн урамшууллыг журам зөрчиж авсан	1	280.5	1	280.5				
Тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгосон боловч давхар цалингийн зардлаас мөнгөн тэтгэмж олгосон	1	799.8			1	799.8		
Төрийн цахим худалдан авалтыг хэрэгжүүлээгүй	1	52003.0					1	52003.0
Дүн	3	53083.3	1	280.5	1	799.8	1	52003.0
Нийт дүн	3	53083.3	1	280.5	1	799.8	1	52003.0